

БАТЛАВ.

Монголбанкны Хяналт
шалгалтын газрын захирал

.....
гүйцэтгэх захирал

.....
/ Д.Ганбат /

.....
/ /

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

Дугаар

..... оны ... дугаар ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

"Зээлийн мэдээллийн тухай" хууль, "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай" хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн нэг талаас Монголбанкны Хяналт шалгалтын газар, нөгөө талаас/улсын бүртгэлийн №....., регистр №/, /цаашид "Зээлдүүлэгч" гэх/ хооронд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. Ерөнхий зүйл

1.1 Хамтын ажиллагааны гэрээ бүхий байгууллагын эрсдэлийг бууруулах, төлбөр хариуцагчийн санхүүгийн хариуцлагыг сайжруулах үүднээс Монголбанкны ажиллуулж буй зээлийн мэдээллийн санд /цаашид "ЗМС" гэх/ болон Зээлдүүлэгчид байгаа иргэд, аж ахуй нэгжийн зээл, хүлээж болзошгүй үүрэг, үнэт цаас, бусад актив, аливаа өр төлбөр болон холбогдох бусад мэдээллийг харилцан солилцоход энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг гэрээнд оролцогч тал нь нөгөө талдаа бичгээр гаргаж, харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлтийг оруулах бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

1.3 Зээлдүүлэгчийн ажилтан албан тушаалтай овогтой нь Монголбанкаас мэдээлэл хүлээн авах, өгөх эрх бүхий итгэмжлэгдсэн ажилтан болно.

ХОЁР. Монголбанкны эрх, үүрэг

2.1 Монголбанк нь дор дурдсан эрх, үүрэгтэй:

2.1.1 ЗМС-г бүрдүүлэх, зээлийн эрсдэлийг бууруулах, мөнгө, санхүүгийн зах зээлийн удирдлагыг оновчтой болгож, шуурхай зөв шийдвэр гаргахад нь туслах зорилгоор ЗМС дахь мэдээллээр хамтын ажиллагааны гэрээ бүхий байгууллагыг хангах,

2.1.2 Хамтын ажиллагааны гэрээ бүхий байгууллагаас мэдээлэл хүлээн авах, илгээх загварыг тэдгээр байгууллагатай харилцан зөвшилцөж боловсруулах,

- 2.1.3 ЗМС-гийн нууцлал, байнгын ажиллагааг хангах талаар зохих арга хэмжээг байнга авч ажиллах,
- 2.1.4 “Зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах,
- 2.1.5 Зээлийн мэдээллийн тухай хууль болон Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх.

ГУРАВ Зээлдүүлэгчийн эрх, үүрэг

3.1 Зээлдүүлэгч нь дор дурдсан эрх, үүрэгтэй:

- 3.1.1. Зээлдүүлэгч нь өөртөө бүртгэлтэй байгаа иргэн, хуулийн этгээдийн ЗМС-д шаардагдах мэдээлэл, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг Монголбанкнаас тогтоосон загварын дагуу мэдээлэлд нэмэлт өөрчлөлт орох тухай бүр тухайн ажлын өдөрт багтаан ЗМС-д мэдээлж байх,
- 3.1.2. Монголбанкт харилцах итгэмжлэгдсэн ажилтныг томилох, солих, эрх бүхий, итгэмжлэгдсэн ажилтан өөрчлөгдөх бүр энэ талаарх мэдэгдлийг эрх бүхий итгэмжлэгдсэн шинэ ажилтны нэрийн хамт тухайн өдөрт нь багтааж Монголбанкинд нууцын зэрэглэлтэй ирүүлэх,
- 3.1.3. ЗМС-гаас авсан лавлагаа, мэдээллийг зөвхөн албан хэрэгцээнд ашиглах,
- 3.1.4. ЗМС-тай мэдээлэл солилцохдоо холбогдох журамд заасан шаардлагыг бүрэн хангах,
- 3.1.5. “Зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах,
- 3.1.6. Зээлийн мэдээллийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх.

ДӨРӨВ. Хариуцлага

4.1. Энэ гэрээний дагуу олж авсан мэдээллийг гэрээнд заасан зориулалтаас өөр бусад зорилгоор ашигласан, бусдад аливаа хэлбэрээр задруулсан, задруулах нөхцлийг бүрдүүлэхийг талуудад хориглоно.

4.2. Зээлдүүлэгч нь энэ гэрээний 4.1-т дурдсан үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээллийг дамжуулах, хүлээн авах, боловсруулах зэрэг тухайн мэдээлэлд нэвтрэх эрх бүхий этгээд, ажилтнуудын үйл ажиллагаа, хариуцлагыг тодорхой зохицуулсан заавар, журмыг баталж, мөрдөж ажиллана. Энэ заавар, журмын нэг хувийг гэрээ байгуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор Зээлийн мэдээллийн санд хүргүүлнэ.

4.3. Энэ гэрээний 4.1-т дурдсан нэг талын үйлдэл нь Эрүүгийн болон холбогдох бусад хууль тогтоомж зөрчсөн байж болзошгүй тохиолдолд энэ талаар зохих эрх бүхий байгууллагад гэрээний нөгөө тал шуурхай мэдээлнэ.

4.4. Зээлийн мэдээллийн сан энэ гэрээний 4.2-т дурдсан заавар, журмын хувийг гэрээний 4.3-т заасан тохиолдол үүсмэгц эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлэх эрхтэй.

4.5. Энэ гэрээг зөрчсөний улмаас бусдад учирсан аливаа хохирлыг тухайн зөрчлийг гаргасан тал бүрэн хариуцна.

ТАВ. Бусад зүйл

5.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

5.2 Зээлдүүлэгчийн ЗМС-аас мэдээлэл авах эрх бүхий ажилтан нь гэрээний хавсралтын дагуу нууцлалын баталгаа гаргаж Монголбанкинд ирүүлнэ.

5.3 ЗМС-ын мэдээлэл нь тодорхой загварын дагуу Монголбанктай гэрээний дагуу хамтран ажиллаж буй зээлдүүлэгчдэд нээлттэй байна.

5.3 Гэрээг 2 /хоёр/ хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр нь хуулийн дагуу адил хүчин төгөлдөр байна.

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Монголбанкны Хяналт шалгалтын
газрын Бүтцийн өөрчлөлт,
бодлогын хэлтсийн захирал

.....

.....
/ Ё.Мөнхбат /

.....
/ /

Монголбанкны Зээлийн
мэдээллийн сангийн ажилтан

Итгэмжлэгдсэн эрх
бүхий ажилтан

.....
/ Д.Төрбат /

.....
/ /

Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал
..... нарын оны
..... сарын өдрийн тоот Хамтын
ажиллаганы гэрээний хавсралт

Байгууллагын нууцтай албан ажлын шаардлагаар танилцсан албан тушаалтнаас
авах баталгаа

БАТАЛГАА

..... оны сарын өдөр

_____ (байгууллагын
нэр)

_____ (албан
тушаал)

_____ овогтой _____ би албан үүргийн дагуу байгууллагын
нууцтай зөвшөөрөгдсөн хэмжээнд танилцах, ашиглахдаа нууцлалыг чанд хадгалж,
хамгаалахаа баталж байна. Хэрэв би өөрт итгэмжлэгдсэн танилцсан байгууллагын
нууцыг үрэгдүүлэх, эсвэл задруулбал, түүнчлэн холбогдох хууль тогтоомжийн
заалтуудыг зөрчвөл Монгол Улсын Эрүүгийн болон холбогдох бусад хууль
тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх болно.

БАТАЛГАА ГАРГАСАН (гарын үсэг)

БАТАЛГАА ГАРГУУЛСАН:

_____ (албан тушаал)

_____ (гарын үсэг)